



“ЖЕНКО ТУР БЮРО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 12 өдөр

Дугаар А/05

Улаанбаатар хот

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ


Монгол улсын компанийн тухай хуулийн 46-р зүйлийн 46.5 дахь заалт, компанийн дүрмийн 2.9, 3.8 дахь заалтууд, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн хурлаас гарсан шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. Женко тур бюро ХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг үндэслэн, цэвэр ашгаас 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөгийн ногдол ашгийг нэгж хувьцаанд 12.5 төгрөгөөр тооцож, хувьцаа эзэмшигчдэд хуваарилсугай.

Хоёр. Бүртгэлийн өдрийг 2026 оны хувьцаа эзэмшигчдийн хурлын өдрөөр тасалбар болгох буюу 04 сарын 30-ны өдөр “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан олгосугай.

Хоёр. Ногдол ашиг хуваарилах тухай тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Ц.Түмэнхишиг/-т үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц. ТҮМЭНХИШИГ



“ЖЕНКО ТУР БЮРО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 12 өдөр

Дугаар А/02

Улаанбаатар хот


КОМПАНИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ТАЛААРХИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол улсын компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн хурлаас гарсан шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. Женко тур бюро ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны тайланг хангалттай гэж үзсүгэй.

Хоёр. Женко тур бюро ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц. ТҮМЭНХИШИГ



“ЖЕНКО ТУР БЮРО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 12 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот


КОМПАНИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХӨНДЛӨНГИЙН АУДИТ ХИЙХ КОМПАНИЙГ СОНГОХ ТУХАЙ

Монгол улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн хурлаас гарсан шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. “Женко тур бюро” ХК-ийн 2025 оны жилийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагаар Интер Аудит ХХК-ийг сонгож, тус компанитай хийх гэрээг хавсралтаар баталсугай.

Хоёр. Төлөөлөн удирдах зөвлөлийн сонгосон аудитын Интер Аудит ХХК-тай гэрээ байгуулж, хамтран ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Намуун/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц. ТҮМЭНХИШИГ



“ЖЕНКО ТУР БЮРО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 12 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

КОМПАНИЙН 2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн хурлаас гарсан шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. Женко тур бюро ХК-ийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт №1-ээр баталсугай.

Хоёр. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Намуун/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц. ТҮМЭНХИШИГ